



БАЙГУУЛАМЖ ОД ХХК
ҮЙЛДВЭР-IV

НИЙСЛЭЛИЙН СОНГИНО ХАЙРХАН ДҮҮРГИЙН 32-Р
ХОРООНД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ
“ТӨМӨРБЕТОН ЭДЛЭЛИЙН ҮЙЛДВЭР БОЛОН БУТАЛЖ
ШИГШСЭН ЭЛС ҮЙЛДВЭРЛЭХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“БАЙГУУЛАМЖ-ОД” ХХК

**Хаяг: СХД-ИЙН 32-Р
ХОРОО ӨӨРИЙН
БАЙР**

Утас/факс: 7000-1657

АГУУЛГА

хуудас

1. Төслийн талаарх мэдээлэл, товч танилцуулга	2
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	3-6
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	7
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8-9
3.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, зорилт	10-11
3.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний	12
3.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13
3.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	14-16
3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөны	17
3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18-21
3.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22,23

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төмөр бетон эдлэлийн үйлдвэр: Тус үйлдвэрийг 2016 оноос “Байгууламж-Од”-ийн охин компани болох “Чиглэл од” ХХК нь 2022 он хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад татан буугдан одоогийн байдлаар “Байгууламж-Од” ХХК нь хариуцан үйлдвэрлэлийг үргэлжлүүлэн ажиллуулж байна. Үйлдвэрийн үндсэн хэсгүүд нь:

- Армартур бэлтгэлийн хэсэг
- Хэв хашмал бэлтгэх хэсэг
- Бетон цутгах хэсэг
- Дулааны боловсруулалтын хэсэг
- Бэлэн бүтээгдэхүүн хураах талбай
- Буталж, шигшсэн элс үйлдвэрлэх
- Бетон зуурмагийн узель гэсэн үндсэн нэгжээс бүрдэнэ.

Төслийн нэр: “Төмөр бетон эдлэлийн үйлдвэр болон буталж шигшсэн элс” үйлдвэрлэх

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Байгууламж-Од ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011071150

Регистрийн дугаар: 2745836

Хаяг:

Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р

хороо, Эрчим хүчиний гудамж

өөрийн байр.

Утас: 99040872 70001657

Төмөрбетон эдлэлийн үйлдвэр болон буталж шигшсэн элс үйлдвэрлэх төсөл нь Байгууламж-Од ХХК-ийн салбар Үйлдвэр IV гэх бөгөөд Япон стандартын дулааны сувгийн тэвш, таг, L-хэлбэрийн хана, хашаа, буталж шигшсэн элсийг үйлдвэрлэж байна. Жилийн хүчин чадал нь Бэлэн бүтээдэхүүний хувьд 5000m^3 угсармал бетон эдлэл, $12000-13000\text{ m}^3$ буталж шигшсэн элс үйлдвэрлэх хүчин чадалтайгаар төслөө үргэлжлүүлж байна.

Төслийн байршил: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. “Байгууламж-Од ХХК-ийн салбар Үйлдвэр IV нь Нийслэлийн Засаг даргын захирамж 2022 оны 03 сарын 28-ны өдрийн A/444 тоот шийдвэрээр 1801600146 дугаар бүхий 61763m^2 талбайтай нэгж талбарыг 15 жилийн хугацаатай, үйлдвэрийн зориулалтаар эзэмшээд үйлдвэрлэлээ явуулж байна.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөлөл нь хөрсний эвдрэл, бохирдол, ажиллагсдын ажлын байрны орчин (гэрэлтүүлэг, чимээ шуугиан, чийгшилт, тоосжилт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл зэрэг) бетоны нэмэлт бодис, тоног төхөөрөмжийн болон авто засварын үйлчилгээнд ашиглагдах тос, тослох материалыг хөрсөнд асгаснаас үүдэх хөрсийг бохирдуулах ба бетон зуурмагийн узелийн цэвэрлэгээний усыг зориулалтын талбайд хуримтлуулаагүй, ил задгай асгаснаас хөрс бохирдох зэрэг асуудал байна.

Төслийн технологийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол сөрөг нөлөөлөл болох усны нөөцийн хэрэглээ болон хаягдал бохир уснаас үүдэлтэй нөлөөллийг бууруулахад гол анхаарлаа хандуулж орчин үеийн дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэн ажиллах шаардлагатай.

Ажилчдын буруу үйл ажиллагаа, санамсар болгоомжгүй байдал, байгалийн хүчин зүйлээс хамаарч аюул осол тохиолдсон үед нөхөж баршгүй хохирол үүсэх тул аюулгүй ажиллагааг дээд зэргээр ханган ажиллах, аюул тохиолдсон үед авах арга хэмжээг нарийн тодорхой болгох шаардлагатай байна.

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт. Байгалийн төрөл зүйлүүдээс зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллийн зэрэг нь “бага”, харин агаар орчны бохирдол, газар доорх усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл бараг дундаас дээш зэрэгтэй байсан бол геологийн тогтцын өөрчлөлтөд хөрсний элэгдэл, эвдрэл ба бохирдол, ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт, усны чанарын өөрчлөлт зэрэг нөлөөлөл дунд зэрэг байхаар гарсан байна.

Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт. Үйлдвэрийн үйл ажиллагааны үед гарах тоос, тоосонцроос бохирдох бохирдол дунд, хөрсний бохирдол, агаар орчны дуу чимээний физик бохирдол, ундны усны чанар хэмжээнд “дунд” зэргээр нөлөөтэй үнэлэгдэж байна. Энд орчны дэд бүтцийн хөгжил, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллүүд зэрэг үзүүлэлттэй байна.

Бусад нөлөөлөл. Автозамын тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих болон байгалийн давагдашгүй хүчин зүйл /хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга/-ийн нөлөөллийн зэрэг “бага” байхаар байна.

ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохицой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННҮ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. Тиймээс төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзээд холбогдох зардлыг төлөвлөнө. Энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх;
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй болох зэрэг болн

1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 1

№	Гол болон большошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар									
1	Тоос шороо үүсэж агаар орчныг бохирдуулах	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх авто машин, механизмын зорчих хурдыг хязгаарлах тэмдэг байршуулах	Тээвэрлэлт үйчилгээнд хэрэглэж буй тээврийн хэрэгсэл	ш	100 000	2	200 000	5-р сард 1 удаа	MNS5013520038 MNS5014:2003
		Хашааны үуд хэсэгт манарсан тоосыг арилгахад бетондох	Үйлдвэрийн хашааны гадна	M ²	5 000	600	3 000 000	6-р сард	-
		Борооны үерийн ус нарийн ширхэгтэй тоос, шороо цуглуулж байгааг суваг далан хийж зайлцуулах		M ²	10 000	300	3 000 000	6-9 сар хооронд	-
Гадаргын болон газрын доорх усны нөөц									
2	Гадаргын ба газрын доорх усны нөөцийн хосдол үүсэх	Ус ашиглалтын талаар сургалт явуулах	Нийт ажилтан	ш	300 000	1	300 000	8 сард 1 удаа	
		Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Төслийн хүрээнд	ш	100 000	1	100 000	7 сард	Усны тухай хуулийн 12.1.4 заалт, БОНХАЖ-ын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015оны А- 30/127тоот хамтарсан тушаалаар батлагдсан УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРҮҮЛ АХУЙН БУСИЙН ДЭГЛЭМИЙН МӨРДӨХ ЖУРАМ-ын 3.9 дэх заалт
		Ус ашиглах гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	ш	x	x	x	6 сард	
		Усны мониторинг	Худаг	ш	162 000	2	340 000	Жилд 1 удаа	

№	Гол болон большогүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Хөрсөн бүрхэвч									
3	Тоос шороо үүсэж агаар орчныг бохирдуулах	Хог хаягдлын ангилан хийх хогийн савыг хийх	Өөрийн үйлдвэр IV	Ш	-	-	-	-	-
	Нийт дүн							6 940 000 төг	

2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ЗОРИЛТ

Хүснэгт 2

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжмх нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ногоон байгууламж <i>/Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байгаа тул төлөвлөгдсөн газрыг бага багаар цэуцэрлэгжүүлэх ажлууд хийгдэж байгаа болно/</i>	Мод тарих	Өөрийн үйлдвэр IV	ш	20	20000	400 000		MNS 6141:2010, MNS 6138:2010, 6258-1:2011 MNS 5918:2008
	Нийт дүн						400 000		

Жил бүр мод зүлэг тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй арчилгааг хуваарийн дагуу гүйцэтгэдэг.

3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулхтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг.

Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд аюулгүй ажиллагааг чанга мөрдөх зайлшгүй шаардлагатай бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг мөрдөн ажилладаг. Төсөл хэрэгжүүлэгч нь ажилтны эрүүл аюулгүй ажиллаж хөдөлмөрлөх орчин болон ажлын байрыг бэлтгэх үүргийг хүлээдэг тул ХАБЭА-н тухай хуулийн шаардлагуудыг хангаж төслийг үргэлжлүүлнэ. Бид аюулгүй ажиллагааг хангах, ямар нэгэн эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг төлөвлөгөөт болон тухайн үеийн эрсдэлийн үнэлгээг хийж ажилладаг. 2020 онд хэрэгжүүлэх ажлуудыг тусгаж өглөө.

Хүснэгт 3

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал /Т/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Өргөн тээвэрлэх машин механизмын эвдрэл гэмтэл	Өргөн тээвэрлэх кран, тайлыг магадлалаар оруулах	Үйлдвэрийн кранууд	2	396 000	792 000	Жилд нэг удаа 9 сард	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй тухай хууль 2008.5 сар
2	Гал түймрээс сэргийлэх	Гал унтраах хуурай хорыг байршуулах	Үйлдэрийн талбай, түр байруудад	3	77000	231 000	1 удаа	
3	Үйлдвэрлэлийн осол гэмтэл, бэртэл	Нийт ажилчдын сургалт зохион байгуулах	Төслийн ажилчид	120	5000	600 000	Жил бүр 3 сард	
	Нийт дүн						1 623 000	

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хүснэгт 4

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам стандарт
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Тусгайлан бэлтгэсэн хогийн саванд хадгалах, хогын цэгт хаях, хоёрдогч түүний эдийн цэгт тушаах	Төслийн талбай	ш	100 000	6	600 000	сард 1 удаа	Хог хаягдлын тухай хууль, хаягдлыг ангилан ялгаж хаях журам
Үйлдвэрийн	Тусгайлан бэлтгэсэн хогийн саванд хадгалах хогын цэгт хаях,	Төслийн талбай	ш	100 000	6	600 000	сард 1 удаа	
Аюултай	x	x	x	x	x	x	x	x
						1 200 000		

Бид Байгаль, болоод хүрээлэн байгаа орчинд ээлтэйгээр төслийг хэрэгжүүлэхээр хичээж байгаа бөгөөд БОННУ-ний зөвлөмж болон хог хаягдлын тухай хуулийн дагуу хог хаяндлын менежментийг хэрэгжүүлнэ.

**6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ,
ЗАРДАЛ**

Хүснэгт 5

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлжж хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар		
		2024 он						
		сар	сар	сар				
БОМТ-нд тусгагдсан ажлын дэлгэрэнгүй төсвийг гаргаж дотооддоо батлах	-	4	-	-	Ц.Булгантамир			
Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн ажлын мэргэжлийн байгууллагатай хамtran хийх	-	-	6	-	Ц.Булгантамир			
Мэргэжлийн байгууллагатай хамtran хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гол түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх	400 000	5	-	-	Ц.Булгантамир			
Байгаль орчныг хамгаалах, хог хаягдаа тогтоосон цэгт хаях, ангилах, Хог хаягдлын хор хөнөөлийн таниулах лекц явуулах	400 000	-	6	-	Ц.Булгантамир			
НИЙТ ДҮН	800 000							

7. ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДАЛ

Хүснэгт 6

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал	
	1	2	3	4	5	6	7	8	
1	Хөрсний механик бүрэлдэхүүн	СХД-ийн 32-р хороо ҮЙЛДВЭР IV Жилд 1 удаа намар, 10 сар	2 удаа	76000	112 000	-	MNS 5850:2008		
2	Хөрсний агрохимиийн найрлага			76000	112 000	-			
3	Хөрсөн дэх пестицидийн гербицидийн үлдэгдэл			52000	104 000	-			
	НИЙТ				328 000				

**8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хүснэгт 7

№	БОМТ,БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаатов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	БГД-ийн 32-р хорооны ИХТөлөөлөгч нар Байгууламж-Од ХХК-н удирдлагууд	Цаасан тайлан	Төслийн БОННҮ-ний дагуу тухайн жилд хийсэн ажлуудыг танилцуулах	10 сард	1 000 000	ХАБЭА-н ажилтан Ц.Булгантамир	Байгууламж-Од ХХК Үйлдвэр IV оффис
2	НБОГ-т тайлагнах, дүгнэх хуудсаар дүгнүүлэх						НБОГ-т
					1 000 000		

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 8

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ, мян.төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6 940 000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	400 000
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	---
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1 623 000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1 200 000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, зардал	800 000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	328 000
Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	1 000 000
Нийт	12 291 000